

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ЭРХЛЭХ
АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

АУДИТЫН КОД: САГ-2018/02/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын хураангуй тайлан	2
2	Аудитын гэрчилгээ	4
3	Аудитын тайлан	6
3.1	Оршил	6
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
3.5	Дотоод аудит.....	8
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
3.7	Шилэн дансны мэдээлэл	9
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	9
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	9
3.9.1	Цалингийн зардлын талаар.....	10
3.9.2	Тээвэр шатахууны зардлын талаар.....	10
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	10
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	10
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	11
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3.16	Аудитын үр өгөөжийн талаар	11
4	Менежментийн захидал.....	12
4.1	Цалингийн зардлын талаар.....	13
4.2	Тээвэр шатахууны зардлын талаар.....	14
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	15
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	15
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	16
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА А.ГАНСҮХ ТАНАА

2018.04.25 № 1044

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0425\SAG34.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0425SAG34.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Гансүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд цалингийн болон тээвэр шатахууны зардлын талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 15-наас 2018 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн



аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 4/154 дүгээр албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Өөрийн орны улс төр, нийгмийн амьдралд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Үндсэн хуулиар тодорхойлсон төр, нийгмийн байгууллыг бататгах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах;
- Монгол Улсын үндэсний баялгийг зүй зохистой ашиглах, үндэсний технологийг хамгаалж, орчин үеийн ололтоор баяжуулан хөгжүүлэх, дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд идэвхтэй, уян хатан оролцох зэргээр эдийн засгаа нөөц бололцоондоо тулгуурлан бие даан хөгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх;
- Үндэсний соёл иргэншил, оюуны өв уламжлал, чадавхийг хамгаалан хөгжүүлэх;
- Монгол Улсын байгалийн баялгаа эзэмших бүрэн эрх, экологийн аюулгүй байдлыг хангах;
- Гадаад орон, олон улсын байгууллагатай төр, засгийн дээд хэмжээний хэлэлцээрийн үед баримтлах чиглэл, гадаад орон, олон улсын байгууллагад тодорхой асуудлаар төр, засгийн дээд хэмжээнд байр сууриа илэрхийлэхдээ төрийн гадаад бодлогод нийцүүлж зөвлөлдөн тогтох;
- Төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
- Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний асуудлаар Улсын Их Хурлаас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 2 арга хэмжээ төлөвлөснөөс 100.0 хувийн биелэлттэй байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.



3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д тэмдэглэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 16 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-З/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит


Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжгүй ба санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна. Тухайлбал: Ажиллагсад олгосон хоол, унааны хөнгөлөлтөөс хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.



Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 2,012.5 сая төгрөгийг баталсан.

Төсөвт зардлын гүйцэтгэлийг 3.7 хувь буюу 73.5 сая төгрөгөөр хэмнэсэн ба төлөвлөсөн зардлууд бүлгийн дүнгээр хэтрээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн бүрэлдэхүүн тайлангуудыг бүрэн бэлтгээгүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
2. Орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/;
3. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл;
4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
5. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр зэрэг болно.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар


Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 16 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратегийн судалгааны хүрээлэнгийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба аудитын түүвэрт хамруулсан болно.



3.9.1 Цалингийн зардлын талаар

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба 2017 оны цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 4.8 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайланд 3.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн, мөн олгохоор тооцсон цалингаас нийгмийн даатгалын шимтгэл 1.1 сая төгрөг, хувь хүний орлогын албан татвар 2.3 сая төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4-т “... гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д “... үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 17 дугаар зүйлийн 17.1.1-д “энэ хуулийн 11.1.1 ...-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

3.9.2 Тээвэр шатахууны зардлын талаар

Тээвэр шатахууны зардалд 33.9 сая төгрөг зарцуулсан бөгөөд дотоод томилолтын зардлаас 4.2 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “төсөв захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5-д зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх 5.1-д “төсвийн байгууллага энэ журмын 3.1-д заасан үндэслэлээр дээд шатны төсөв захирагчаас зөвшөөрөл авсны дагуу 4.1-д заасан агуулга бүхий зардлын бүлэг хооронд хийх зохицуулалтын саналаа харьяа төрийн санд хүргүүлнэ”, 5.5-д Төсөв захирагч энэ журмын 5.2, 5.4 дэх заалтанд зааснаас бусад зохицуулалтын саналаа харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлан төсвийн сар, улирлын хуваарь өөрчлөлт оруулна шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал


Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны 2017 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаар тайлагнасан 450.0 сая төгрөг нууцын зэрэглэлтэй учир санхүүгийн тайлангийн аудитад хамруулаагүй болно.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд нарийвчилсан горим сорил төлөвлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 15.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.



Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 15.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж хүргүүлээ.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 2017 оны завсрын аудитаар 3 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01-1062 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 1,998.7 сая төгрөг бөгөөд 1.0 хувь буюу 20.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

3.16 Аудитын үр өгөөжийн талаар

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар материаллаг алдаа зөрчил илрээгүй тул үр өгөөжийг тооцоолоогүй болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Цалингийн зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба 2017 оны цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 4.8 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайланд 3.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн, мөн олгохоор тооцсон цалингаас нийгмийн даатгалын шимтгэл 1.1 сая төгрөг, хувь хүний орлогын албан татвар 2.3 сая төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4-т “... гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д “... үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 17 дугаар зүйлийн 17.1.1-д “энэ хуулийн 11.1.1 ...-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, цалин илүү олгогдох, татвар, шимтгэл дутуу төлөгдөх оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламжийн мэдэгдлүүд хангагдахгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Тээвэр шатахууны зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тээвэр шатахууны зардалд 33.9 сая төгрөг зарцуулсан бөгөөд дотоод томилолтын зардлаас 4.2 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “төсөв захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5-д зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх 5.1-д “төсвийн байгууллага энэ журмын 3.1-д заасан үндэслэлээр дээд шатны төсөв захирагчаас зөвшөөрөл авсны дагуу 4.1-д заасан агуулга бүхий зардлын бүлэг хооронд хийх зохицуулалтын саналаа харьяа төрийн санд хүргүүлнэ”, 5.5-д Төсөв захирагч энэ журмын 5.2, 5.4 дэх заалтанд зааснаас бусад зохицуулалтын саналаа харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлан төсвийн сар, улирлын хуваарь өөрчлөлт оруулна шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, сангийн сайдын тушаал хэрэгжихгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 73 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах:

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
Эргэлтийн хөрөнгийн дүн	75,091.4	78,379.6
Мөнгөн хөрөнгө		
Авлага	49,136.1	44,266.4
Бараа материал	25,955.3	34,113.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	205,696.4	156,288.8
Үндсэн хөрөнгө	205,696.4	156,288.8
Биет хөрөнгө	205,696.4	156,288.8
Биет бус хөрөнгө		
Нийт хөрөнгийн дүн	280,787.8	234,668.4
Нийт өр төлбөр	4,869.7	
Богино хугацаат өр төлбөр	4,869.7	
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	275,918.1	234,668.4
Засгийн газрын хувь оролцоо	275,918.1	234,668.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	655,686.9	655,686.9
Хуримтлагдсан үр дүн	(382,360.2)	(423,609.9)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	280,787.8	234,668.4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,036,996.6	1,957,470.1
Татварын бус орлого	82,702.6	157.5
Нийтлэг татварын бус орлого	82,702.6	157.5
Төсөв байгууллагын өөрийн орлого	82,702.6	-
Тусламжийн орлого		
Тусламж, санхүүжилтийн орлого	1,962,677.5	1,957,312.6
Улсын төвлөрсөн төсвөөс	1,954,293.9	1,957,312.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	8,383.6	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,236,727.3	1,998,719.7
Урсгал зардал	2,236,727.3	1,998,719.7
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,133,962.1	1,885,891.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,064,476.3	1,066,668.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,979.1	93,400.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,355.7	-
Хангамж, бараа материалын зардал	96,841.8	68,806.7
Нормативт зардал	2,770.7	
Эд хогшил, урсгал засварын зардал	10,141.0	9,463.5
Томилолт, зочны зардал	27,488.7	37,257.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	517,746.9	551,568.3
Бараа үйлчилгээний бусад зардал	261,161.9	58,726.0
Урсгал шилжүүлэг	111,077.9	112,828.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,675.3	5,205.5
Бусад урсгал шилжүүлэг	97,089.8	89,154.2
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,312.7	18,469.0
Үйл ажиллагааны үр дүн	(199,730.7)	(41,249.7)
Үйл ажиллагааны бус зардлын дүн	250,344.9	
Үйл ажиллагааны нийт үр дүн	(450,004.8)	(41,249.7)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,743.6		675,743.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	50,179.3		50,179.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	725,922.8		725,922.8
Тайлант үеийн үр дүн	-450,004.8		-450,004.8
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,918.1		275,918.1
2017 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	275,918.1		275,918.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,918.1		275,918.1
Тайлант үеийн үр дүн	41,249.7		41,249.7
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,668.4		234,668.4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,974,147.2	1,957,470.1
Татварын бус орлого	4,869.7	157.5
Нийтлэг татварын бус орлого	4,869.7	157.5
Тусламж, санхүүжилтийн орлого	1,969,277.5	1,957,312.6
Улсын төвлөрсөн төсвөөс	1,954,293.9	1,957,312.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,974,147.2	1,957,470.1
Урсгал зардал	1,974,147.2	1,957,470.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,858,199.6	1,844,641.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,064,394.5	1,046,524.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,060.9	113,544.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,355.7	-
Хангамж, бараа материалын зардал	77,859.6	72,118.4
Нормативт зардал	2,933.6	-
Эд хогшил, урсгал засварын зардал	10,141.0	9,463.5
Томилолт, зочны зардал	27,488.7	37,257.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	517,539.7	556,414.6
Бараа үйлчилгээний бусад зардал	4,425.9	9,318.5
Урсгал шилжүүлэг	115,947.6	112,828.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,675.3	5,205.5
Бусад урсгал шилжүүлэг	97,089.8	89,154.2
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,182.5	18,469.0
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	-	-
Хөрөнгийн зардал	-	-
Дотоод эх үүсвэрээр	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,012,517.3	1,939,001.0	73,516.3	96.4
УРСГАЛ ЗАРДАЛ	2,012,517.3	1,939,001.0	73,516.3	96.4
Бараа ажил үйлчилгээний зардал	1,851,268.4	1,844,641.3	6,627.1	99.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,048,040.7	1,046,524.5	1,516.2	99.9
Үндсэн цалин	787,632.4	751,804.2	35,828.2	95.5
Нэмэгдэл	234,089.3	268,401.3	(34,312.0)	114.7
Унаа хоолны хөнгөлөлт	26,319.0	26,319.0	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,284.3	113,544.7	1,739.6	98.5
Тэтгэврийн даатгал	73,362.8	72,043.8	1,319.0	98.2
Тэтгэмжийн даатгал	10,480.2	9,149.1	1,331.1	87.3
ҮОМШӨ-ний даатгал	8,384.4	9,526.8	(1,142.4)	113.6
Ажилгүйдлийн даатгал	2,096.1	2,074.5	21.6	99.0
Эрүүл мэндийн даатгал	20,960.8	20,750.5	210.3	99.0
Хангамж, бараа материалын зардал	74,149.3	72,118.4	2,030.9	97.3
Бичиг хэрэг	14,541.8	12,399.7	2,142.1	85.3
Тээвэр, шатахуун	19,788.3	17,794.7	1,993.6	89.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,227.3	29,734.0	(3,506.7)	113.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	681.6	-	681.6	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,910.3	12,190.0	720.3	94.4
Эд хогшил, урсгал засварын зардал	9,485.0	9,463.5	21.5	99.8
Урсгал засвар	9,485.0	9,463.5	21.5	99.8
Томилолт, зочны зардал	37,257.1	37,257.1	-	100.0
Дотоод албан томилолт	37,257.1	37,257.1	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	556,918.7	556,414.6	504.1	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,072.3	555,619.7	452.6	99.9
Даатгалын үйлчилгээ	495.0	490.7	4.3	99.1
Тээврийн хэрэгслийн татвар	351.4	304.2	47.2	86.6
Бараа үйлчилгээний бусад зардал	10,133.3	9,318.5	814.8	92.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,445.0	4,630.2	814.8	85.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,688.3	4,688.3	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,248.9	94,359.7	66,889.2	58.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,507.0	5,205.5	1,301.5	80.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	6,507.0	5,205.5	1,301.5	80.0
Бусад урсгал шилжүүлэг	154,741.9	89,154.2	65,587.7	57.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	126,541.9	71,337.2	55,204.7	56.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,200.0	17,817.1	10,382.9	63.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,012,517.3	1,939,001.0	73,516.3	96.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,012,517.3	1,939,001.0	73,516.3	96.4
Улсын төсвөөс санхүүжих	2,012,517.3	1,939,001.0	73,516.3	96.4
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	-	100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	95	95	-	100
Удирдах ажилтан	6	6	-	100
Гүйцэтгэх ажилтан	78	78	-	100
Үйлчлэх ажилтан	11	11	-	100

